



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/69/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Отгонбаяр

Утас: 89306788 Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг. Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsগুল@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.24 № 01/128
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РЭНЧИНЛХҮМБЭ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА О.ЭНХТҮВШИН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	60,822,845.02	72,112,399.02
33	АВЛАГА	3,503,582.00	150,062.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	150,062.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,503,582.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,319,263.02	71,962,337.02
354	Хангамжийн материал	57,319,263.02	71,962,337.02
35410	Бичиг хэргийн материал	1,184,150.00	1,444,960.00
35420	Аж ахуйн материал	51,397,113.02	65,783,273.02
35440	Түлш, шатах тослох материал	4,500,000.00	4,640,104.00
35450	Барилгын засварын материал	238,000.00	94,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,345,631,350.07	1,565,250,394.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,345,631,350.07	1,565,250,394.43
392	Биет хөрөнгө	1,185,501,350.03	1,403,565,394.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	556,869,702.14	556,869,702.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,839,150.80	-72,231,995.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	298,704,349.22	385,554,983.22
39204	Хуримтлагдсан элэгдэл	-244,335,572.86	-57,890,749.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,204,131.80	70,944,232.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-85,301,019.00	-26,380,073.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,859,114.00	22,514,114.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,422,238.37	-10,425,381.57
39209	Зам, гүүрийн байгууламж	417,902,312.50	417,902,312.50
39210	Хуримтлагдсан элэгдэл	-121,621,437.42	-146,655,849.84
39214	Бусад үндсэн хөрөнгө	355,044,273.83	355,044,273.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	-54,563,115.01	-91,680,173.85
393	Биет бус хөрөнгө	160,130,000.04	161,685,000.08
39301	Програм хангамж	4,572,000.00	4,572,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,751,999.96	-2,196,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	159,310,000.00	159,310,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,406,454,195.09	1,637,362,793.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,338,640.00	40.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,338,640.00	40.00
413	Өглөг	4,338,640.00	40.00
4136	Бусад өглөг	4,338,640.00	40.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,338,640.00	40.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,402,115,555.09	1,637,362,753.45
51	Засгийн газрын хувь оролцоо	1,402,115,555.09	1,637,362,753.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	871,793,172.06	871,793,172.06
51101	Өмч: - төрийн	871,793,172.06	871,793,172.06
512	Хуримтлагдсан үр дүн	198,856,239.74	434,663,439.10
51210	Өмнөх үеийн үр дүн	198,856,239.74	199,416,240.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	235,247,198.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	331,466,143.29	330,906,142.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,406,454,195.09	1,637,362,793.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	542,194,378.68	814,182,426.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	143,337,058.68	339,741,956.00
120	Нийтлэг татварын бус орлого	143,337,058.68	339,741,956.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	143,337,058.68	339,741,956.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	143,337,058.68	332,301,396.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ		7,440,560.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,857,320.00	474,440,470.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,340,320.00	22,757,770.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,835,820.00	8,745,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,504,500.00	14,012,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	385,517,000.00	451,682,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	385,517,000.00	451,682,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	507,460,439.28	578,935,227.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	506,120,879.28	578,935,227.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,619,635.28	560,900,070.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,425,459.00	271,832,185.00
210101	Үндсэн цалин	256,085,459.00	271,832,185.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,340,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,361,219.00	34,343,199.00
210201	Тэтгэврийн даатгал	22,694,037.00	24,349,443.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,560,806.00	2,718,322.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,048,645.00	2,174,656.00
210204	Ажилгүйдлийн даатгал	456,893.00	463,708.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,600,838.00	4,637,070.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,647,934.50	13,222,089.00
210301	Гэрэл, цахилгаан	1,624,458.00	1,766,810.00
210302	Түлш, халаалт	14,624,576.50	9,859,896.00
210303	Цэвэр, бохир ус	1,398,900.00	1,595,383.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,633,303.00	48,415,130.00
210401	Бичиг хэрэг	4,930,750.00	4,870,690.00
210402	Тээвэр, шатахуун	26,640,503.00	31,474,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,469,800.00	3,750,000.00
210404	Ном, хэвлэл	15,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,660,000.00	3,923,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,917,250.00	4,396,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,009,700.00	34,087,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,500.00	00.00
210604	Урсгал засвар	2,997,200.00	34,087,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,970,000.00	3,196,000.00
210702	Дотоод албан томилолт	2,970,000.00	3,196,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,824,855.00	24,885,526.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,755,118.00	23,862,830.00

210803	Даатгалын үйлчилгээ	94,000.00	264,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	279,800.00	280,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	566,500.00	396,000.00
210807	Газрын төлбөр	79,437.00	82,496.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,747,164.78	130,918,141.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,646,800.00	13,401,390.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,697,500.00	734,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,402,864.78	116,782,251.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,501,244.00	18,035,157.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	3,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	3,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,401,244.00	14,935,157.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,401,244.00	14,935,157.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,339,560.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,339,560.00	00.00
223001	Бусад хөрөнгө	1,339,560.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	34,733,939.40	235,247,198.36
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	34,733,939.40	235,247,198.36

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,793,172.06	151,441,680.34	1,354,752,995.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	52,000.00	52,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	871,793,172.06	151,441,680.34	1,354,804,995.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	-52,000.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	47,362,559.40	47,362,559.40
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,793,172.06	198,856,239.74	1,402,115,555.09
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,793,172.06	198,856,239.74	1,402,115,555.09
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	560,001.00	560,001.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	871,793,172.06	199,416,240.74	1,402,675,556.09
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-560,001.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	235,247,198.36	235,247,198.36
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,793,172.06	434,663,439.10	1,637,362,753.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	399,834,320.00	477,944,052.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	399,834,320.00	477,944,052.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,317,320.00	26,261,352.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,713,820.00	8,745,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,603,500.00	17,515,582.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	385,517,000.00	451,682,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	385,517,000.00	451,682,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	399,834,320.00	473,844,152.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,834,320.00	473,844,152.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	376,993,516.00	451,470,395.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,425,458.28	271,832,185.00
210101	Үндсэн цалин	256,085,458.28	221,347,656.00
210102	Нэмэгдэл	00.00	50,484,529.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,340,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,361,219.72	34,493,261.00
210201	Тэтгэврийн даатгал	22,216,519.72	23,601,761.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,536,200.00	2,722,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,029,000.00	2,178,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	507,200.00	544,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,072,300.00	5,445,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,223,358.00	13,362,193.00
210301	Гэрэл, цахилгаан	1,624,458.00	1,766,810.00
210302	Түлш, халаалт	10,200,000.00	10,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,398,900.00	1,595,383.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,152,825.00	48,559,340.00
210401	Бичиг хэрэг	4,670,700.00	5,131,500.00
210402	Тээвэр, шатахуун	26,558,325.00	31,474,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,648,800.00	3,750,000.00
210404	Ном, хэвлэл	15,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,660,000.00	3,923,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,600,000.00	4,280,100.00
2105	Нормативт зардал	2,500,000.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,092,500.00	34,052,900.00
210602	Тавилга	2,000,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	92,500.00	00.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	34,052,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,970,000.00	3,196,000.00
210702	Дотоод албан томилолт	2,970,000.00	3,196,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,923,855.00	26,741,106.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,854,118.00	25,718,410.00
210803	Даатгалын үйлчилгээ	94,000.00	264,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	279,800.00	280,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	566,500.00	396,000.00
210807	Газрын төлбөр	79,437.00	82,496.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,344,300.00	17,733,410.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,646,800.00	16,998,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,697,500.00	734,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,840,804.00	22,373,757.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	3,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	3,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,339,560.00	4,338,600.00
213304	Хөрөнгийн	1,339,560.00	4,338,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,401,244.00	14,935,157.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,401,244.00	14,935,157.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,099,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,099,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,099,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,099,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,099,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,099,900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	451,682,700.0	435,431,645.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	451,682,700.0	435,431,645.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,482,700.0	433,231,645.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,288,000.0	271,832,185.0
210101	Үндсэн цалин	221,288,000.0	221,347,656.0
210102	Нэмэгдэл	51,000,000.0	50,484,529.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,403,400.0	34,493,261.0
210201	Тэтгэврийн даатгал	23,511,900.0	23,601,761.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,722,900.0	2,722,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,178,300.0	2,178,300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	544,500.0	544,500.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,445,800.0	5,445,800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,600,000.0	13,362,193.0
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.0	1,766,810.0
210302	Түлш, халаалт	10,000,000.0	10,000,000.0

210303	Цэвэр, бохир ус	1,600,000.0	1,595,383.0
2104	Хангамж, бараа материалын зардал	42,100,400.0	41,977,840.0
210401	Бичиг хэрэг	4,800,000.0	4,800,000.0
210402	Тээвэр, шатахуун	25,236,800.0	25,224,240.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,750,000.0	3,750,000.0
210404	Ном, хэвлэл	110,000.0	00.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,923,500.0	3,923,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,280,100.0	4,280,100.0
2105	Нормативт зардал	1,500,000.0	1,500,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,500,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,152,900.0	38,152,800.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,100,000.0	4,099,900.0
210604	Урсгал засвар	34,052,900.0	34,052,900.0
2107	Томилолт, зочны зардал	3,200,000.0	3,196,000.0
210702	Дотоод албан томилолт	3,200,000.0	3,196,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,503,500.0	10,983,956.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,131,300.0	9,961,260.0
210803	Даатгалын үйлчилгээ	264,200.0	264,200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,000.0	280,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.0	00.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.0	396,000.0
210807	Газрын төлбөр	168,000.0	82,496.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,734,500.0	17,733,410.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,000,000.0	16,998,910.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	734,500.0	734,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,200,000.0	2,200,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,200,000.0	2,200,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.0	2,200,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.0	4,338,600.0
2200	Дотоод эх үүсвэрээр	00.0	4,338,600.0
223001	Бусад хөрөнгө	00.0	4,338,600.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	451,682,700.0	439,770,245.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	451,682,700.0	439,770,245.0
132001	Орон нутгийн төсвөөс	451,682,700.0	439,770,245.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	09.00	09.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,238,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,238,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,338,650.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,581,500.00
210401	Бичиг хэрэг	331,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,757,150.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,757,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,238,650.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,238,650.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,245,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,992,880.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Сангийн сайдын 190 дугаар тушаал болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газар нь төр иргэний харилцааг ил тод нээлттэй болгож, иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа бодлогын баримт бичгийг Аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар тушаалаар баталж мөрдсөн байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын зөвлөлийг Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан байна. Дотоод хяналтын зөвлөл нь тайлант онд нийт 5 ажил хийхээр төлөвлөсөн байна. Үүнээс 5 ажил нь байгууллагын санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой байна. Дотоод хяналтын зөвлөлийн ажлыг тайланд төлөвлөгөөнд тусгагдсан бүх ажилд хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан талаар дурдсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 399.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1
Дансны авлага	3.5	0.2	(3.4)
Бараа материал	57.3	72.0	14.6
Үндсэн хөрөнгө	1,345.6	1,565.3	219.6
Биет бус хөрөнгө	160.1	161.7	1.6
Нийт хөрөнгө	1,406.5	1,637.4	230.9
Дансны өглөг	4.3	0.0	(4.3)
Эздийн өмч	871.8	871.8	-
-төрийн	871.8	871.8	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	331.5	330.9	(0.6)
Хуримтлагдсан үр дүн	198.9	434.7	235.8

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,406.5	1,637.4	230.9
--	---------	---------	-------

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0 төгрөг.

Бараа материалын дансны үлдэгдэл 14.6 сая төгрөгөөр өссөн нь хамгаалах хувцас хэрэглэл болон хууль бусаар бэлтгэсэн модыг хурааж орлого авсан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө данс 219.6 сая төгрөгөөр өссөн байна. ОНХС-аас шилжүүлэн авсан 144.2 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, Улсын онцгой комиссоос 60.0 сая төгрөгийн усны машиныг үнэ төлбөргүй орлого авсан болон 91.6 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэ тогтоож орлого авсан байна.

Нийгмийн даатгалын хэлтсээс шимтгэлийн авлага 0.2 сая төгрөгийн авлага үүссэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төслийг урсгал зардалд 409.0 сая төгрөгөөр төлөвлөж саналаа хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 22.6 сая төгрөгөөр бууруулж 386.4 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор 65.3 сая төгрөг нэмэгдэж 451.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 3 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 451.7 сая төгрөгийн төсөв баталж орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 451.7 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч, 439.8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 11.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

Хөтөлбөр, арга хэмжээ	Арга хэмжээний код нэр	Зардлын дүн		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	426.5	425.5	1	100
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	335.1	334.1	1	100
80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	72.2	72.2	0	100
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал	2.2	2.2	0	100
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	17	17	0	100
70503	Хөрөнгө оруулалт		4.3	-4.3	
80918	Бусад		4.3	-4.3	
71413	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	25.1	9.9	15.2	39
81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	25.1	9.9	15.2	39
	Нийт дүн	451.7	439.8	11.9	97

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд усны хөнгөлөлтийн үнэ 9.6 сая, статистикийн хэлтсээс 1.2 сая, Аймгийн ЗДТГ-ийн нөөц хөрөнгөөс шар усны далан барихад 3.9 сая, өвсний фонд үүсгэхэд 2.5 сая төгрөг, ариутгал халдваргүйжүүлэлтийн үнэ 2.7 сая, цахим тендерийн орлого 0.9 сая төгрөг нийт 26.2 сая төгрөгийн орлого орж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд шар усны үер, ковид-19 цар тахал болон халдварт шүлхий өвчин зэргээс хамааран тасралтгүй үйл ажиллагаа явуулсан бөгөөд 11.9 сая төгрөгийг хэмнэж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд Эрүүл мэндийн төвөөс 29.7 сая төгрөгийн автомашин, Улсын онцгой комиссоос 60.0 сая төгрөгийн усны машин, Орон нутгийн хөгжлийн сангаас 144.2 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл тус тус үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ нь 2021 онд Шилэн дансны цахим хуудсанд нийт 14.1 сая төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй, 750.9 сая төгрөгийн 77 мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажилласан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын улсын бүртгэлийн гэрчилгээ дэх дүрмийн сангийн хэмжээ 71,999,000.00 төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн дүн 871,793,172.06 төгрөг байгаа ба 799,794,172.06 төгрөгөөр зөрүүтэй байна. Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын улсын бүртгэлийн гэрчилгээ дэх дүрмийн санд өөрчлөлт хийлгэх шаардлагатай гэж үзлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн зөвлөмж байхгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.0 сая төгрөгийн алдааг залруулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 14.5 сая төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 3.0 сая төгрөгийн гүйлгээг шууд зардалд бичсэнийг тооцооны дансаар бүртгэж залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн хэмнэлттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас сургалтын төлбөрт 0.4 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж байна. Энэ нь “нийцсэн бөгөөд зохистой байх” гээн батламж мэдээдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 14.1 сая төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-ийг зөрчсөн байна. Энэ нь иж бүрэн байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах



Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дүгээр сарын 19-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ	3	17.5	1	3.0					2	14.5

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН: АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Э.БАТ-ЭРДЭНЭ

Д.ОТГОНБАЯР